

Үйлчилгээний нөхцөл

Энэхүү үйлчилгээний нөхцөл нь форекс сургалтын цахим платформ буюу www.gccapital.mn вэб сайт (цаашид “Сайт” гэх)-аар дамжуулан хэрэглэгчдэд “Генгис Кровн Капитал” ХХК (цаашид “үйлчилгээ үзүүлэгч” гэх)-ийн бэлтгэсэн албан ёсны форекс цогц сургалт, дадлагажуулах хөтөлбөр бүхий үйлчилгээг үзүүлэх, түүний нөхцөлийг тогтоох ба зөвшөөрсөн иргэн (цаашид “хэрэглэгч” гэх) үйлчилгээ авах эрхтэй болно. Үйлчилгээний нөхцөл нь хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх гэрээтэй ижил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Нэр томъёоны тайлбар:

1. “Форекс арилжаа” гэж Олон Улсын валют, хувьцаа, үнэт метал зэргийг цахим хэлбэрээр хөшүүрэг ашиглан арилжаалахыг;
2. “Сайт” гэж үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс иргэдэд үзүүлж буй форекс арилжааны мэдлэг, мэдээллийг онлайнаар хүргэж буй хэрэгслийг;
3. “ICT-SMC арга барил” гэж форекс арилжаанд оролцогч томоохон этгээдийн ашиглаж буй алгоритм, компьютер бүхий аргыг тайлбарласан Micheal Huddleson гэх этгээдийн зохион боловсруулсан аргачлалыг хэлнэ;
4. “Бүртгэл” гэж энэхүү нөхцөлийн дагуу www.gccapital.com-д үүсгэсэн хэрэглэгчийн бүртгэлийг;
5. “Хэрэглэгч” гэж энэхүү үйлчилгээний нөхцлийн дагуу өөрийн бүртгэлийг үүсгэн төлбөрийг төлж баталгаажуулсан Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэнийг;
6. “Мөнгө угаах” гэх гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;
7. "Терроризмыг санхүүжүүлэх" гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;
8. “Live trading” буюу лайв арилжаа гэж үйлчилгээ үзүүлэгчийн томилсон аливаа этгээд онлайн хэлбэрээр форекс арилжаанд оролцохдоо үзсэн хичээлийг бататгах зорилгоор бодит цаг хугацаанд буй ханшид тулгуурлан тайлбарлахыг;

1. Үйлчилгээний тодорхойлолт

1.1. Үйлчилгээ үзүүлэгч нь сайтаар дамжуулан хэрэглэгчид форексийн зах зээлийн онолын мэдлэг, арилжааны үндсэн ойлголт, ICT - Smart Money concept стратеги, эрсдэлийн удирдлага зэрэг сэдвээр онлайн сургалтын хөтөлбөр, хичээл, материал, зөвлөмжийг хүргэнэ.

1.2. Үйлчилгээ нь **зөвхөн мэдлэг олж авах зорилготой** бөгөөд ямар ч хэлбэрээр хөрөнгө оруулалтын зөвлөмж, арилжааны шууд удирдлага үзүүлэхгүй.

1.3. Үйлчилгээ үзүүлэгч нь сайтаар дамжуулан Smart Money Concept форекс арилжааны арга барилын талаар бүрэн хэмжээний цогц мэдлэгийг олгох видео контент, дагалдах бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүртээнэ.

1.4. Үйлчилгээ үзүүлэгчийн 1.3-т заасан үндсэн болон дагалдах бүтээгдэхүүн гэдэгт аливаа санхүүгийн зөвлөгөө, форекс арилжааны шийдвэр багтахгүй бөгөөд хэрэглэгч арилжаанд оролцох нөхцөлөө сайн дурын үндсэн дээр дангаар шийдвэрлэнэ.

2. Хэрэглэгчийн үүрэг, хариуцлага

2.1. Хэрэглэгч сургалтад хамрагдахын өмнө форекс зах зээлийн өндөр эрсдэлтэй мөнгөний арилжаа гэдгийг ойлгож, өр төлбөрийн болон санхүүгийн аливаа эрсдэлийг бүрэн өөрөө хариуцах үүрэгтэй.

2.2. Сургалтаар олж авсан мэдлэгийг ашиглан хийсэн арилжаа, хөрөнгө оруулалтын үр дүн, ашиг, алдагдалд Сайт болон үйлчилгээ үзүүлэгч **ямар нэгэн байдлаар хариуцлага хүлээхгүй.**

2.3. Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг нууцлан хадгалах үүрэгтэй.

2.4. Хэрэглэгч та манай www.gccapital.mn веб сайтад бүртгүүлснээр энэхүү “Үйлчилгээний нөхцөл”-ийг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Хэрэв та энэхүү үйлчилгээний нөхцөлтэй санал нийлэхгүй бол өөрийн бүртгэлийг устгах, гэрээг цуцлах, манай үйлчилгээг бүрэн зогсоох эрхтэй.

2.5. Хэрэглэгч үйлчилгээний бүртгэлээ үүсгэж баталгаажуулан төлбөрийг төлсөн тохиолдолд сургалтын хөтөлбөр, видео хичээл нээгдэх ба энэ тохиолдолд үйлчилгээг зогсоох боломжгүй.

2.6. Хэрэглэгч үйлчилгээ авч буй видео контентыг хуулбарлах, хуваах, хууль бусаар бусдад тараахгүй байх үүргийг хүлээнэ. Энэхүү үүргээ зөрчсөн нь хууль, хяналтын байгууллагын шийдвэрээр тогтоогдвол **Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.**

3. Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага

3.1. Вэб сайтаар дамжуулан Smart Money Concept форекс арилжааны мэдлэгийг цогц, системтэйгээр хэрэглэгчид хүргэх контентийг чанартай, тодорхой хөтөлбөр бүтэцтэйгээр хүргэх.

3.2. Форекс арилжааны ерөнхий ойлголт, зах зээлийн зарчим, эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэгийг хуулийн хүрээнд түгээх.

3.3. Хэрэглэгчийн хувийн мэдээллийг нууцлах, гуравдагч этгээдэд задруулахгүй байх.

3.4. Вэб платформ болон хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээнд хамаарах видео контентуудын оюуны өмчийг эзэмших бөгөөд аливаа хууль бусаар задруулсан этгээдэд хуулийн хариуцлага оногдуулахаар хууль, хяналтын байгууллагад гомдол, шаардлага гаргах эрхтэй байна.

4. Төлбөрийн нөхцөл

4.1. Үйлчилгээний төлбөр нь урьдчилан төлөгдөх бөгөөд буцаан олголт хийхгүй.

4.2. Төлбөрийн гүйлгээг хүлээн авснаар Хэрэглэгч үйлчилгээнд бүртгэгдэж, үйлчилгээнд хандах эрхтэй болно.

5. Хариуцлагаас чөлөөлөх

5.1. Форекс зах зээл нь арилжааны туршлага, мэдлэг, сэтгэл зүйн өндөр шаардлагатай тулгардаг тул хөрөнгө оруулалтын бүх шийдвэрийг Хэрэглэгч өөрөө бие даан гаргаж хариуцлагыг хүлээнэ.

5.2. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн хийсэн арилжааны үр дүн, ашиг, алдагдал, санхүүгийн сахилга бат зэрэг үйлчилгээний контентод тавигдах шаардлагаас бусад асуудалд аливаа хууль, эрх зүйн хариуцлага хүлээхгүй

5.3. Сургалтын агуулга нь **зөвхөн боловсролын зорилготой** бөгөөд арилжаанд оролцох зөвлөмж биш.

6. Оюуны өмч, нууцлалын бодлого

6.1. Сургалтын материал, контент, видео, текст, график, загвар нь үйлчилгээ үзүүлэгчийн оюуны өмч бөгөөд зөвшөөрөлгүй хуулбарлах, түгээх, худалдахыг хатуу хориглоно.

6.2. Хэрэглэгчийн зүгээс “Генгис Кровн Капитал” ХХК-ийн оюуны өмчийн бүртгэлтэй энэхүү үйлчилгээг хуулбарласан, хууль бусаар тараасан тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

7.1. Үйлчилгээ үзүүлэгч энэхүү нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд шинэчлэлтийг сайт дээр нийтэлснээр хүчин төгөлдөр болно.

Анхааруулга: Энэхүү үйлчилгээний нөхцөлтэй холбоотой асуулт, тодруулах зүйл байвал манай компанийн info@gccapital.mn цахим хаягаар холбогдоно уу.

Манай “Генгис Кровн Капитал” ХХК нь хэрэглэгчтэй албан бус хаягаар харилцах, дансны бүртгэл, нэвтрэх нэр, нууц үг, зэрэг бусад хувийн мэдээллийг шаардахгүй тул мэдээллийн аюулгүй байдлаа сайтар хангаж, цахим залилангийн шинжтэй хууран мэхлэх үйлдлээс урьдчилан сэргийлэхийг хүсье.